



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЕП	Улсын ерөнхий прокурор
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/14

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан барилга 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр ашиглалтад орсон бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр гараагүй тул байгууллагын хөрөнгөд бүртгэж аваагүй байна.

Шинэ барилга ашиглалтад орсонтой холбоотойгоор тус байгууллагын тайлант оны төсөв 58,743.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, мөн УЕПГ-аас 26,563.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 10,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

005020141

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан.

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>51,697,970.00</u>	<u>47,806,850.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,142,700.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,142,700.00
3121	Төгрөг	00.00	2,142,700.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	2,142,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	51,697,970.00	45,664,150.00
354	Хангамжийн материал	51,697,970.00	45,664,150.00
35410	Бичиг хэргийн материал	8,220,520.00	4,154,500.00
35420	Аж ахуйн материал	29,327,350.00	28,050,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,958,300.00	1,267,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,191,800.00	12,191,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>692,329,193.63</u>	<u>708,194,689.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	692,329,193.63	708,194,689.71
392	Биет хөрөнгө	659,829,193.63	675,694,689.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	511,201,480.00	511,201,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,960,074.36	-34,546,765.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	75,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,074,999.94	-34,641,666.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,236,292.91	150,889,642.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,711,663.47	-50,424,565.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,944,576.96	87,764,576.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,506,418.47	-30,348,011.89
393	Биет бус хөрөнгө	32,500,000.00	32,500,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,500,000.00	32,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>744,027,163.63</u>	<u>756,001,539.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>2,142,700.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,142,700.00
414	Урьдчилж орсон орлого	00.00	2,142,700.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	00.00	2,142,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>744,027,163.63</u>	<u>753,858,839.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	744,027,163.63	753,858,839.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	421,403,922.12	421,403,922.12
51101	Өмч: - төрийн	421,403,922.12	421,403,922.12
512	Хуримтлагдсан үр дүн	110,167,961.43	119,999,637.51
51210	Өмнөх үеийн үр дүн	110,167,961.43	110,167,961.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,831,676.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,455,280.08	212,455,280.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>744,027,163.63</u>	<u>756,001,539.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	797,578,814.00	805,590,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,873,914.00	58,563,350.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,873,914.00	58,563,350.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,704,900.00	747,027,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,464,900.00	747,027,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,464,900.00	747,027,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	671,173,731.68	795,758,773.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,173,731.68	795,758,773.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,704,669.68	732,727,596.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,977,843.00	506,814,349.55
210101	Үндсэн цалин	437,298,936.00	300,079,704.76
210102	Нэмэгдэл	16,281,637.00	163,284,581.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,397,270.00	24,012,232.57
210104	Урамшуулал	00.00	19,437,830.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,195,188.00	61,858,664.33
210201	Тэтгэврийн даатгал	45,218,251.00	42,286,186.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,121,614.00	4,974,843.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,441,837.00	3,949,634.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,629.00	967,999.98
210205	Эрүүл мэндийн даатгал	5,216,857.00	9,679,999.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,090,799.00	35,457,833.92
210301	Гэрэл, цахилгаан	2,891,119.00	4,515,105.92
210302	Түлш, халаалт	23,440,120.00	25,666,810.00
210303	Цэвэр, бохир ус	759,560.00	5,275,918.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,669,959.00	48,743,782.06
210401	Бичиг хэрэг	7,092,900.00	17,098,970.00
210402	Тээвэр, шатахуун	7,102,563.00	10,098,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,528,346.00	3,866,068.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,451,150.00	5,825,782.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	11,254,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,850,100.00	2,987,600.00
210604	Урсгал засвар	53,850,100.00	2,987,600.00
2107	Томилолт, зочны зардал	492,000.00	1,582,000.00
210702	Дотоод албан томилолт	492,000.00	1,582,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,634,375.00	11,554,513.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,120,900.00	10,814,885.00

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	960,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,700.00	215,628.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	00.00
210807	Газрын төлбөр	130,000.00	130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,794,405.68	63,728,853.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,117,500.00	2,121,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,719,350.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,957,555.68	61,607,853.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,469,062.00	63,031,177.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,469,062.00	60,781,177.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,469,062.00	60,781,177.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>126,405,082.32</u>	<u>9,831,676.08</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>126,405,082.32</u>	<u>9,831,676.08</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>763,704,900.00</u>	<u>749,169,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,142,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,142,700.00
120009	Бусад орлого	00.00	2,142,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,704,900.00	747,027,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	763,464,900.00	747,027,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	763,464,900.00	747,027,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	240,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>699,705,700.00</u>	<u>728,117,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,705,700.00	728,117,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,236,638.00	665,085,922.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,041,513.00	506,814,349.55
210101	Үндсэн цалин	300,149,970.00	300,079,704.76
210102	Нэмэгдэл	137,274,909.00	163,284,581.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,616,634.00	24,012,232.57
210104	Урамшуулал	00.00	19,437,830.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,131,518.00	61,858,664.33
210201	Тэтгэврийн даатгал	41,509,551.00	42,286,186.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,410,784.00	4,974,843.60

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,528,623.00	3,949,634.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,497,626.00	967,999.98
210205	Эрүүл мэндийн даатгал	6,184,934.00	9,679,999.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,090,799.00	35,457,833.92
210301	Гэрэл, цахилгаан	2,673,278.00	4,515,105.92
210302	Түлш, халаалт	23,440,120.00	25,666,810.00
210303	Цэвэр, бохир ус	977,401.00	5,275,918.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,222,933.00	29,053,112.06
210401	Бичиг хэрэг	13,656,200.00	10,487,850.00
210402	Тээвэр, шатахуун	8,637,037.00	10,098,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,452,996.00	3,813,568.06
210404	Ном, хэвлэл	3,909,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,567,700.00	3,902,882.00
2105	Нормативт зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,934,700.00	6,680,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	498,000.00	1,090,000.00
210604	Урсгал засвар	67,436,700.00	5,590,300.00
2107	Томилолт, зочны зардал	492,000.00	1,582,000.00
210702	Дотоод албан томилолт	492,000.00	1,582,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,997,875.00	16,630,663.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,484,400.00	15,891,035.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	960,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	213,700.00	215,628.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	00.00
210807	Газрын төлбөр	130,000.00	130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,325,300.00	5,509,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,035,900.00	5,409,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,289,400.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,469,062.00	63,031,177.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,469,062.00	60,781,177.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,469,062.00	60,781,177.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,999,200.00	21,052,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,999,200.00	18,910,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,999,200.00	18,910,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,999,200.00	18,910,000.00

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,999,200.00	18,910,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-63,999,200.00</u>	<u>-18,910,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,142,700.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,142,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	17,336,239.46	00.00	651,195,441.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	17,336,239.46	00.00	651,195,441.66
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	126,405,082.32	00.00	126,405,082.32
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	110,167,961.43	00.00	744,027,163.63
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	110,167,961.43	00.00	744,027,163.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	110,167,961.43	00.00	744,027,163.63
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,831,676.08	00.00	9,831,676.08
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	119,999,637.51	00.00	753,858,839.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	747,027,100.00	686,245,922.86	60,781,177.14	91.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,027,100.00	686,245,922.86	60,781,177.14	91.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	744,767,100.00	683,995,922.86	60,771,177.14	91.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,024,200.00	506,814,349.55	42,209,850.45	92.3
210101	Үндсэн цалин	312,396,300.00	300,079,704.76	12,316,595.24	96.1
210102	Нэмэгдэл	193,023,900.00	163,284,581.88	29,739,318.12	84.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,528,000.00	24,012,232.57	6,515,767.43	78.7
210104	Урамшуулал	13,076,000.00	19,437,830.34	-6,361,830.34	148.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,628,000.00	61,858,664.33	6,769,335.67	90.1
210201	Тэтгэврийн даатгал	46,903,900.00	42,286,186.10	4,617,713.90	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,431,000.00	4,974,843.60	456,156.40	91.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,344,800.00	3,949,634.98	395,165.02	90.9

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210204	Ажилгүйдлийн даатгал	1,086,200.00	967,999.98	118,200.02	89.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,862,100.00	9,679,999.67	1,182,100.33	89.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,961,600.00	35,457,833.92	1,503,766.08	95.9
210301	Гэрэл, цахилгаан	5,188,700.00	4,515,105.92	673,594.08	87.0
210302	Түлш, халаалт	26,186,100.00	25,666,810.00	519,290.00	98.0
210303	Цэвэр, бохир ус	5,586,800.00	5,275,918.00	310,882.00	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	29,587,000.00	29,053,112.06	533,887.94	98.2
210401	Бичиг хэрэг	9,674,000.00	10,487,850.00	-813,850.00	108.4
210402	Тээвэр, шатахуун	10,100,000.00	10,098,812.00	1,188.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,602,000.00	3,813,568.06	788,431.94	82.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,451,000.00	750,000.00	701,000.00	51.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,760,000.00	3,902,882.00	-142,882.00	103.8
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,592,000.00	25,590,300.00	1,700.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,592,000.00	5,590,300.00	1,700.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	1,582,000.00	3,218,000.00	33.0
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	1,582,000.00	3,218,000.00	33.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,074,700.00	16,630,663.00	1,444,037.00	92.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,335,000.00	15,891,035.00	1,443,965.00	91.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,700.00	215,628.00	72.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	130,000.00	130,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10599600.00	5509000.00	5,090,600.00	52.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,599,600.00	5,409,000.00	190,600.00	96.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	100,000.00	4,900,000.00	2.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2260000.00	2250000.00	10,000.00	99.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,260,000.00	2,250,000.00	10,000.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	2,250,000.00	10,000.00	99.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	747,027,100.00	686,245,922.86	60,781,177.14	91.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	747,027,100.00	686,245,922.86	60,781,177.14	91.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	747,027,100.00	686,245,922.86	60,781,177.14	91.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,142,700.00	-2,142,700.00	#DIV/0!

Баянхонгор аймгийн Прокурорын газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	23.00	1.00	95.8
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	15.00	1.00	93.8
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	23.00	1.00	95.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	01.00	01.00	0.00	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	09.00	09.00	0.00	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	03.00	02.00	1.00	66.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь Монгол Улсын үндсэн хуульд заасан прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх хэмжээ, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтоох зэрэг зорилго зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэгтэй байгууллага юм.

Прокурорын газар нь 9 прокурор, захиргааны 4 ажилтан, төрийн үйлчилгээний 11 албан хаагч нийт 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд 747,027.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Тамгын дарга Б.Төрболд (2022.01.01-2022.03.14), Ч.Бодибямбаа (2022.04.05-2022.12.31), 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Бодибямбаа (2022.01.01-2022.04.05), П.Нямдэлгэр (2022.04.07-2022.10.24), Б.Даваажаргал (2022.11.10-2022.12.31) нар зурж, няраваар Г.Ганчимэг ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

МУЕПГ-т Дотоод хяналт, шалгалтын хэлтэс ажилладаг, 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдөр “Дотоод аудиторын ажиллах журам”-ыг баталсан бөгөөд

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг МУЕП-ын 2021 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан “Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 756,001.5 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 11,974.3 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,142.7	2,142.7
Авлага	-	-	-
Бараа материал	51,697.9	45,664.1	(6,033.8)
Үндсэн хөрөнгө	848,982.3	858,555.7	9,573.4
Хуримтлагдсан элэгдэл	(156,653.2)	(150,361.0)	6,292.2
Нийт хөрөнгө	744,027.2	756,001.5	11,974.3
Өр төлбөр	-	2,142.7	2,142.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	744,027.2	753,858.8	9,831.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	744,027.2	756,001.5	11,974.6

Дээрх хүснэгтээс харахад, тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй, тайлант оны эцэст 2,142.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь эд хөрөнгийн барьцаа дансанд хэрэг нь шийдэгдэх хүртэл байх мөнгөн хөрөнгийг байршуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,664.1 мянган төгрөг болж өмнөх оноос 6,033.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 41,176.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 11,254.1 мянган төгрөгийн бараа материалыг Баянхонгор аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурорын 2022.12.13-ны өдрийн А/27 тушаалаар акталсан, үйл ажиллагаандаа 35,956.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 708,194.6 мянган төгрөг болж 15,865.5 мянган төгрөгөөр өссөн нь 18,910.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, Улсын Ерөнхий Прокурорын 2022 оны А/101 дүгээр тушаалаар УЕПГ-аас 26,563.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, мөн Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/705 дугаар захирамжаар 10,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан, түүнчлэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 67,900.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 08-00 БНР улсын дугаартай Ниссан маркийн автомашиныг УЕП-ын 2022 оны А/62 дугаар тушаалаар дахин үнэлж ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж, үнийг 22,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоон орлогод авсантай тус тус холбоотой байна.

Тайлант оны эцэст 2,142.7 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь эд хөрөнгийн барьцаа данснаас хэрэг шийдэгдэхэд шилжих хөрөнгийн үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 9,831.6 мянган төгрөгөөр өсөж 756,001.5 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 800,796.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 800,796.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төслийн саналаас 112,512.9 сая төгрөгөөр бууруулж 688,283.5 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Тайлант оны эцэст тодотголоор 747,027.1 мянган төгрөг болгож 58,743.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан албаны шинэ байрыг хүлээн авсантай холбоотой 2 жижүүрийг шинээр ажилд авч төсөвт 5,920.0 мянган төгрөгийн

цалин, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын төлбөр 740.0 мянга, тавилга эд хогшил, урсгал засварын зардал 24,392.0 мянга, хангамж бараа материалын зардал 5,887.0 мянга, нормын хувцас зөөлөн эдлэл 1,500.0 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардал 10,599.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 9,974.7 мянга, томилолт 600.0 мянга, нэг удаагийн мөнгөн тэтгэмж урамшуулалд 2,260.0 мянган төгрөгийг нэмж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,129.7 мянган төгрөгөөр хасах тодотголыг тус тус хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 747,027.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 747,027.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 686,245.9 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 60,592.8 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 10.0 мянга, байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 178.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70703 Прокурорын хяналт	747,027.1	686,245.9	60,781.2	91.9
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	738,667.1	678,074.3	60,592.8	91.8
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,260.0	2,250.0	10.0	99.6
4	82315 Байцаан шийтгэх ажиллагаа	6,100.0	5,921.6	178.4	97.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Эд хөрөнгийн барьцаа дансанд 2.242,7 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1/77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 777,330.5 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 777,330.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,659.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,161.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 745,997.1 мянган төгрөгийг мэдээлэхээс 3 гүйлгээний 1,030.0 мянган төгрөгийн мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээний 20,000.0 мянган төгрөгийн мэдээлэл мэдээлэхийг үнэн зөв мэдээлсэн байна. Мөн бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан 3 гэрээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, дутуу мэдээлсэн 3 гүйлгээний 1,030.0 мянган төгрөгийн мэдээлэл, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг байршуулж, цаашид мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан байна..

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан барилга ашиглалтад орсноор 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдөр шилжин орж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй тул тус барилга хөрөнгөд бүртгэлгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 95.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

1. Тайлант хугацаанд 5 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 19 хоногийн хоолны зардалд 95.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай чиг үүргийн байгууллагын хувьд албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны мөнгийг давхардуулан олгох эсэхийг НБББББ-т тодорхой тусгаж хэрэгжүүлэн төсвийн хөрөнгөд тавих хяналтаа сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 5 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 19 хоногийн хоолны зардалд 95.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна	1	95.0						1	95.0			
Дүн	1	95.0	0	0	0	0	0	1	95.0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 мөнгөн гүйлгээний 1,030.0 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна.	1	1,030.0									1	1,030.0
Дүн	1	1,030.0	0	0	0	0	0	0	0	0	1	1,030.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	1,030.0	0	0	0	0	0	0	0	0	1	1,030.0

00000